

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ӨНДӨРХААН НИСЭХ БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЙЛАН

2020.10.22

Хэрлэн сум
1 дүгээр баг

ИНЕГ-ын даргын баталсан 2020 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн ИНЕГ-ын харьяа Хэнтий аймаг дахь Өндөрхаан нисэх буудлын үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх тухай 28/20 тоот удирдамжийн хүрээнд дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ.

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын ДАА-ны ахлах аудитор Л.Жаргалсайхан, санхүүгийн хяналтын мэргэжилтэн Б.Болормаа нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2020 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 21-ний өдрийг дуустал хугацаанд дотоод аудитыг хийсэн.

ИНЕГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд Хэнтий аймаг дахь Өндөрхаан нисэх буудлын 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал хугацааны үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журам болон дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, нягтлан бодох бүртгэл, цалин хөлсний бодолт, олголт, төсөв гүйцэтгэл, дотоод хяналт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус багийн үйл ажиллагаа, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт зэргийг үндсэн баримт нотолгоонд тулгуурлан шалгах, зарим эргэлзээтэй зүйлүүд дээр холбогдох албан тушаалтнаас тайлбар, тодруулга авч ажиллалаа.

Нисэх буудлын 2019 оны санхүүгийн тайланд МУ-ын Төрийн аудитын тухай хуулийн холбогдох заалтын дагуу Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газраас аудит хийж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргасан байна.

2020 онд аймгийн Онцгой байдлын газрын гал унтраах, аврах 32 дугаар ангитай хамтран онцгой байдлын сургалтыг зохион байгуулжээ.

Ажилтнуудын хувийн хэргийн бүрдлийг үзэхэд хувийн хэргийн бүрдүүлэлт, хөтлөлт, баяжилт, эмх цэгц сайн байна.

Цалин хөлс, түүнтэй адилтгах бусад мөнгөн тооцоотой холбоотой татвар, шимтгэлийн тайланг хуулийн хугацаанд тооцоо нийлж баталгаажуулсан.

Дизель генераторуудын ажиллагаа жигдэрсэн, тухайн сард ажилласан мото/цагийн заалттай тулгасны үндсэн дээр шатахууны тооцоог хийж байна. Цахилгаан тасарсан үед аймгийн эрчим хүчний газраас тухай бүр тодорхойлолтыг авч хэвшсэн байна.

Түлш, шатахууны тооллогоор тооллогоор зөрчил илрээгүй.

Нисэх буудлын удирдлага болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэд зөвлөл хууль, тогтоомж болон Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/01 дүгээр тушаал, Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 253 дугаар тушаалуудыг өөрийн нэгж дээр хэрэгжүүлэн ажиллах төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Тушаалын тэргүүг буруу бичих, буруу дугаарлах, тушаалын бичвэр үг, үсэг, утга, найруулгын алдаа ихтэй байна. Албан бичгийн тэргүүг хэвлэмэл хуудсанд тавьсан тэмдэглэгээнд багтааж, стандартын дагуу бичигдээгүй, тэмдэглэгээний дээр бичигдсэн эсвэл тэмдэглэгээнээс илүү гарган бичсэн, “Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”-ын 2.4 дүгээр зүйлийг мөрдөж ажиллаагүй байна.

Удаан жил ажилласны нэмэгдэл хувийг буруу тооцоолсноор цалин хөлсний тооцоогоор зөрчил .

Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбарыг хавсаргаагүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10 дахь заалтыг зөрчсөн байна.

Дотоод хяналтын багийн гишүүдийн хяналт тавих, шалгалт хийх ажлын туршлага, мэдлэг хангалтгүй байгаагаас хяналт шалгалтын үр дүн муу, тайлан бичилт хангалтгүй байна.

Байгууллагын нэр дээрх орон сууцыг эзэмшүүлэх гэрээг хугацаагүйгээр байгуулсан байгаа нь ...төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээг 1 /нэг/ хүртэл жилийн хугацаагаар холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн байгуулна... гэж заасныг зөрчсөн байна.

Аудитын шалтгалтын үр дүнд гарсан алдаа, дутагдлыг арилгах, залруулах талаар тус нисэх буудалд 9 зөвлөмж өгсөн болно.

ДОТООД АУДИТЫН АЛБА